

ҮЕНЧ СУМЫН ЗДТГ

**ҮЕНЧ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ДОТУУР БАЙРНЫ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: **ХОАҮЕСЗДТГ/202301001**

ҮЕНЧ СУМ 2023 ОН

БАТЛАВ:

ҮЕНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Э.УРТНАСАН

**ҮЕНЧ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ДОТУУР БАЙРНЫ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: **ХОАҮЕСЗДТГ/202304001**

ҮЕНЧ СУМ 2023 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо:	2023 оны 01-р сарын 19
Тендер шалгаруулалтын нэр:	Үенч сумын ЕБС-ийн 2023 оны хичээлийн жилд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар:	ХОАҮЕСЗДТГ/202301001

Үенч сумын ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Үенч сумын ЕБС-ийн 2023 оны Дотуур байрны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн үнийн саналаа ирүүлэхийг урьж байна.

Багц-1: Мах махан бүтээгдэхүүн

Багц-2: Сүү цагаан идээ

Багц-3: Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ

Багц-4: Гурил болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2023 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 11 цаг 00, минут-аас өмнө www.tender.gov.mn** гэсэн хаягаар **цахим хэлбэрээр** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2023 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 11 цаг 30 минут-д** нээнэ.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авна.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Ховд аймгийн Үенч сум, Засаг Даргын Тамгын Газрын байр

2 давхар 205 тоот Утас: 94951040, 95101204

Вэб: www.tender.gov.mn

E-mail: nganbaatar5@gmail.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ /хүчинтэй хугацаа дуусаагүй байх/ 3. Хүнсний бүтээгдэхүүн худалдаалах зөвшөөрлийн эсвэл тохирлын гэрчилгээ / хүчинтэй хугацаа дуусаагүй байх/ 4. НӨАТ-ын баримт өгдөг байх 5. Татварын тодорхойлолт 6. Мал эмнэлгийн гарал үүслийн ариун цэврийн гэрчилгээ /багц 1,2/ 7. Малын А карт /багц 1,2/ 8. Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг / багц 3,4/ 9. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг аудитоор баталгаажуулсан байх 10. Гарын үсэг, тамга тэмдэг бүрэн гүйцэд байх 11. Нэр хаяг бүрэн гүйцэд зөв байх
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2023 оны 02-р сарын 19-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p> <p>Байгууллагын хаяг: Үенч сум, ЗДТГ</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхарт, 205 тоот</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: 2023 оны 02-р сарын 19-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут</p> <p>Байгууллагын хаяг: Үенч сум, ЗДТГ</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхарт, 205 тоот</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Нэр: Үенч сумын ЕБС-ийн 2023 оны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх</p> <p>Дугаар: ХОАҮЕСЗДТГ/202301001</p> <p>Багц-1: Мах, махан бүтээгдэхүүн</p> <p>Багц-2: Сүү, цагаан идээ</p> <p>Багц-3: Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ</p> <p>Багц-4: Гурил болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Д/д	Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	2	4	5	6	7	8
Багц-1: Мах, махан бүтээгдэхүүн							
1	Үхрийн мах	Орон нутгийн цул болон ястай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
2	Хонины мах	Орон нутгийн цул болон ястай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
3	Ямааны мах	Орон нутгийн цул болон ястай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
4	Адууны мах	Орон нутгийн цул болон ястай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
5	Цувдай	Орон нутгийн цул болон ястай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
Багц-2: Сүү, цагаан идээ							
1	Сүү	Монгол үнээний	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
2	Тараг	Монгол үнээний	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
3	Аарц	Монгол үнээний	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
Багц-3: Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ							
1	Төмс	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
2	Шар манжин	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
3	Хүрэн манжин	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
4	Лууван	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
5	Байцай	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
6	Сонгино	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
7	Сармис	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
8	Сармисны гол	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
9	Брокли байцай	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
10	Чинжүү	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	

11	Чацарга на	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
12	Алим	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
13	Үзэм	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
14	Аньс	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
15	Зөгийн бал	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
16	Ранетка	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
17	Үрэл	Монгол орос үрийн дотоодын	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
Багц-4: Гурил болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн							
1	Гурил	50кг-ын савалгаатай дотоодын 1-р зэргийн	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
2	Хар гурил	5, 10, 25кг-ын савалгаатай дотоодын 1-р зэргийн	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
3	Ширхэгтэй гурил	5, 10, 25кг-ын савалгаатай дотоодын 1-р зэргийн	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
4	Дээд гурил	5, 10, 25кг-ын савалгаатай дотоодын 1-р зэргийн	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
5	Бор гурил	Орон нутагт үйлдвэрлэсэн	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
6	Цагаан будаа	25кг-ын савлагаатай японы сакура болон түүнтэй дүйцэхүйц	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
7	Шар будаа	1кг-ын савалгаатай /слава/	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
8	Гурвалжин будаа	1кг-ын савалгаатай /слава/	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
9	Хөц будаа	1кг-ын савалгаатай /слава/	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	
10	Хүүхдийн будаа	1кг-ын савалгаатай /слава/	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2022.12.31	

11	Гоймон	Лапша болон түүнтэй дүйцэхүйц	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
12	Гоймон	Дун хэлбэрийн 5кг-ын савлагаатай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
13	Давс	Иоджуулсан 1кг-ын савлагаатай	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
14	Каш	1кг-ын савлагаатай /слава/	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
15	Элсэн чихэр	Нарийн ширхэгтэй орос	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.30	2023.12.31	
16	Ургамлын тос	1 литрийн савлагаатай SUNNY GOLD болон түүнтэй дүйцэхүйц	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.30	2023.12.31	
17	Лавровый лист	Орос	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
18	Шөлний далайн байцай	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
19	Будааны далайн байцай	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
20	Цай	Төрөл бүрийн хятадаас бусад	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
21	Исгэгч /хөөлт/	Төрөл бүрийн хятадаас бусад	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
22	Кекс хөөлгөгч	Төрөл бүрийн хятадаас бусад	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
23	Укроп	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
24	Вандуй	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
25	Эрдэнэ шиш	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
26	Вариан	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	
27	Хар перец	Орос, дотоод	Кг	Үенч сумын ЕБС	2023.02.20	2023.12.31	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ				Нэгжийн дундаж үнэ
			02-р сарын 20-наас 06-р сарын 15-нийг дуустал	09-р сарын 01-наас 12-р сарын 31-нийг дуустал	09-р сарын 01-наас 12-р сарын 31-нийг дуустал	01-р сарын 1-нээс 01-р сарын 15-нийг дуустал	
Тендерийн нийт үнэ							

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших**
 - 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
 - 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.

3. **Оюуны өмчийн эрх** 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. **Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. **Баталгаат засварын хугацаа** 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. **Гэрээнд өөрчлөлт оруулах** 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. **Төлбөр** 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. **Бараа нийлүүлэх хуваарь** 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. **Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. **Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. **Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Захиалагчийн төлөөлөгч бүрэлдэхүүний (мах, гурил, тараг г.м) дээжээс авч нэг удаа туршиж үзнэ.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1 Баталгаат засварын тусгай шаардлага. Хүчинтэй байх хугацааны үлдсэн хоног хамгийн багадаа 10 сараас доошгүй байх
- 4. Төлбөр (ГЕН-7)**
- 7.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний нийт үнийн дүнг (100%) барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН-9)**
- 9.1 Алданги оногдуулах хувь: Нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0,5% байна.
- Алдангийн нийт дүн: Алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10% байна.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____
нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

